



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/337

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоол, аймгийн онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд “COVID-19”-ын цар тахалын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай зардлын урьдчилгаа санхүүжилтийн зардалд 50000.0 мянган төгрөг /тавин сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 50000.0 мянган төгрөгийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 50 000 000.00 төгрөгийг аймгийн 2021 оны төсөвт тухайн зардлын батлагдсан эх үүсвэрээс нөхөн тооцоо хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
07 дугаар сарын 08-ны өдрийн  
А/337 дугаар захирамжийн хавсралт

“COVID-19”-ЫН ЦАР ТАХАЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ  
ГАМШГААС ХАМГААЛАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

дд	Байгууллагын нэр	Зориулалт	Нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1.	Аймгийн Эрүүл мэндийн газар	PCR шинжилгээний оношлогоо	PCR-ийн шинжилгээний оношлуур	ш	1000	20000.00	20000.0
			PCR-ийн автомат ялгагч	ш	839	7151.37	6000.0
			Хурдавчилсан тест	ш	2000	12000.00	24000.0
Дүн							50000.0

-оОо-